



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Иргэний зориг ногоон намын дүрэмд оруулсан
нэмэлт, өөрчлөлт, тус намын даргаар
Б.Батбаатар сонгогдсоныг
улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, С.Соёмбо-Эрдэнэ, П.Соёл-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

“Иргэний зориг ногоон намын дүрмийн 14.5.2, 22.1.16, 27.4, 28.5-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсныг, намын даргаар Б.Батбаатар сонгогдсоныг бүртгүүлэх тухай” Б.Батбаатарын өргөдлийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Өргөдөл гаргагч Б.Батбаатараас 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/001 дүгээр албан бичгээр “... Иргэний зориг ногоон намын Үндэсний хорооны 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хурлын 04 дүгээр тогтоолоор тус намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн өдрийн 06 дугаар тогтоолоор намын даргаас Ц.Ганхуяг чөлөөлөгдөж, Б.Батбаатарыг намын даргаар сонгож, батламжилсан. Иймд Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлд Иргэний зориг ногоон намын дүрмийн өөрчлөлт болон шинээр сонгогдсон намын дарга Б.Батбаатарыг бүртгэж өгнө үү ...” гэсэн агуулгатай өргөдлийг Улсын дээд шүүхэд ирүүлэв.

Тус өргөдөлд нийт 95 хуудас бүхий дараах 17 баримтыг хавсаргажээ. Үүнд:

1.Улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай албан бичиг, Б.Батбаатарын иргэний үнэмлэхний хуулбар 2 хуудас;

2.Намын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл №2, Намын үүсгэн байгуулсан баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийн хавсралт (Журмын хавсралт №2А-ын дагуу) 2 хуудас;

3.Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь) 1 хуудас;

4.Улс төрийн зөвлөлийн хурлын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Үндэсний хорооны хурлыг товлож, хэлэлцэх асуудлаа баталсан тухай” 03 дугаар тогтоол, тус тогтоолын 1, 2 дугаар хавсралт 3 хуудас;

5.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Үндэсний хорооны хурал даргалагч, тэргүүлэгч, тооллогын комисс, редакцын комиссыг тус тус баталж, орон нутгийн намын хорооноос цахимаар оролцсон

Үндэсний хорооны гишүүдийн ирц тоо мэдээг мэдэгдэж ажиллахыг аймаг, дүүргийн намын хорооны дарга нарт даалгасан тухай” 01 дүгээр тогтоол 1 хуудас;

6.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Үндэсний хорооны хурлын гишүүдийн бүртгэлд өөрчлөлт оруулж, Үндэсний хорооны хурлын гишүүдийг 103 байхаар баталсан тухай” 02 дугаар тогтоол, тус тогтоолын хавсралт 7 хуудас;

7.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Улс төрийн зөвлөлийн хурлаас Үндэсний хорооны хурлаар шийдвэрлүүлэхээр ирүүлсэн асуудлыг хэлэлцэхээр баталсан тухай” 03 дугаар тогтоол 1 хуудас;

8.Үндэсний хорооны хурлын тооллогын комиссын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол 1 хуудас;

9.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Намын дүрмийн 14.5.2, 22.1.16, 27.4, 28.5-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай” 04 дүгээр тогтоол 1 хуудас;

10.Намын дүрэм (2 хувь) 20 хуудас;

11.Үндэсний хорооны хурлын тооллогын комиссын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоол 1 хуудас;

12.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Иргэний зориг ногоон намын дарга Ц.Ганхуягийг өөрийн хүсэлтээр чөлөөлж, Б.Батбаатар намын даргаар сонгогдсоныг батламжилсан тухай” 06 дугаар тогтоол 1 хуудас;

13.Ц.Ганхуягийн намын даргаас чөлөөлөгдөх тухай хүсэлт 1 хуудас;

14.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “тус өдрийн хурал болон хурлаар шийдвэрлэсэн асуудал хүчин төгөлдөр болохыг баталгаажуулсан тухай” 08 дугаар тогтоол 1 хуудас;

15.Үндэсний хорооны хуралд цахимаар болон биечлэн оролцсон гишүүдийн ирцийн тэмдэглэл 4 хуудас;

16.Үндэсний хорооны хурлын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн тэмдэглэл (хурлын аудио бичлэг 1 ширхэг сиди) 26 хуудас;

17.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн 1 хуудас баримт байна.

Улсын дээд шүүхийн шүүгчээс Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 3.2-т “Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь мэдээлэл, бүрдэл дутуу бол шүүгч 5 хүртэл хоногийн хугацаа тогтоож, шаардлагатай баримт бичгийг ирүүлэх замаар бүрдэл хангуулж болно ...” гэж заасны дагуу шүүгч 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр бүрдүүлбэр хангуулах хугацаа олгосон, өргөдөл гаргагчаас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/011 дүгээр албан бичгээр нэмэлт тайлбар, Улс төрийн зөвлөлийн хурлын ирцийн тэмдэглэл, тус хурлын тэмдэглэл, Үндэсний хорооны гишүүдэд хурлын тов мэдэгдсэн тэмдэглэл, Иргэний зориг ногоон намын 9 дүгээр Их хурлын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үндэсний хорооны бүрэн эрхийг дуусгавар болгох тухай” 08 дугаар тогтоол, тус Их хурлын “Үндэсний хороог шинээр сонгож байгуулах тухай” 09 дүгээр тогтоол, тус тогтоолын хавсралт Үндэсний хорооны гишүүдийн нэрс, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Иргэний зориг ногоон намын Хэрэг эрхлэх газраас хийсэн Үндэсний хорооны гишүүдийн судалгаа, намаас гарах тухай гишүүдийн хүсэлт, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр цахимаар оролцсон гишүүдийн баримтын хуулбарыг

ирүүлсэн байна. Мөн 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/012 дугаар албан бичгээр Иргэний зориг ногоон намын дарга Ц.Ганхуяг, дэд дарга А.Бархүү, ерөнхий нарийн бичгийн дарга С.Батбаатар нараас "... зөрчил маргаан байхгүй талаарх тодруулга", видео бичлэг 1 ширхэг сиди ирүүлжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан дараах үндэслэлээр "Иргэний зориг ногоон намын дүрмийн 14.5.2, 22.1.16, 27.4, 28.5-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан болон намын даргаар Б.Батбаатар сонгогдсон"-ыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэв.

Өргөдөлд дурдсанаар, "Иргэний зориг ногоон намын Үндэсний хорооны хурал 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж, Үндэсний хорооны хурлын гишүүдийн бүртгэлд өөрчлөлт оруулж, Үндэсний хорооны хурлын гишүүдийг 103 байхаар баталсан, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Үндэсний хорооны уг хуралдаанд тус хурлаас шинээр баталсан 103 гишүүний 75 гишүүн буюу 72.8 хувь нь оролцсон" гэж, уг хуралдаантай холбоотой баримтууд ирүүлжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна", 13 дугаар зүйлийн 13.1-д "Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна" гэж заасан, Иргэний зориг ногоон намын дүрмийн 18.1-д "Намын Удирдах дээд байгууллага нь "Улс төрийн намын тухай" хуульд заасны дагуу тус намын "Их хурал" байна", 19.1-д "Дараахь асуудлыг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу зөвхөн намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд: 19.1.2. намын даргыг сонгох, чөлөөлөх; 19.1.4. Үндэсний хороог сонгож байгуулах, бүрэн эрхийн хугацааны тайланг хэлэлцэх" гэж, намын даргыг сонгож чөлөөлөх болон тус намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний хороог сонгож байгуулах бүрэн эрхийг намын удирдах дээд байгууллага болох тус намын Их хурал эдлэхээр тус тус заасан байна.

Өргөдөлд дурдсан, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хуралдсан гэх Үндэсний хорооны хурал нь "Үндэсний хорооны хурлын гишүүдийн бүртгэлд өөрчлөлт оруулж, Үндэсний хорооны хурлын гишүүдийг 103 байхаар баталсан"-ыг Үндэсний хороог сонгож байгуулах агуулгад хамааралгүй гэж үзэхгүй, Үндэсний хорооны хуралд "Үндэсний хороог сонгож байгуулах эрх" намын дүрмээр олгогдоогүй тул тус хурлаас батлагдсан Үндэсний хороо, түүнээс гаргасан шийдвэрийг намын дүрэмд нийцсэн гэж үзэхээргүй байна.

Намын дүрмийн 22.1.1-д "Үндэсний хороо нь намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах"-аар заасан хэдий ч дүрмийн 20.1-д зааснаар "Их Хурлаас сонгогдсон Үндэсний хороо ..." -нд дээрх эрх хэмжээг олгосон гэж үзэх тул 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Үндэсний хорооны хурлаас батлагдсан гишүүд оролцож хуралдсан гэх Үндэсний хорооны хурлыг хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлгүй, уг хурлаас намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгэх боломжгүй.

Түүнчлэн, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хуралдсан гэх Үндэсний хорооны хурлаар "намын дарга Ц.Ганхуягийг өөрийн хүсэлтээр чөлөөлж, Б.Батбаатар намын даргаар сонгогдсоныг батламжилсан" нь тус намын дүрмийн 19.1.2-т заасан намын Их хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар буюу Үндэсний хороо өөрийн эрх хэмжээнд хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, намын дүрмийн дээрх заалтуудад нийцээгүй гэж нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

Иргэний зориг ногоон намын дүрмийн дагуу тус намын эрх бүхий этгээдээс намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан болон намын даргыг чөлөөлсөн,

сонгосон талаарх шийдвэрээ намын дүрмэндээ нийцүүлэн гаргаснаар уг өөрчлөлтүүдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлөө дахин гаргах боломжтой болохыг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай (2005) хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасныг тус тус баримтлан “Иргэний зориг ногоон намын дүрмийн 14.5.2, 22.1.16, 27.4, 28.5-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан болон намын даргаар Б.Батбаатар сонгогдсон”-ыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА